



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ДАШЗЭГВИЙН АМАРБАЯСГАЛАН
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2024.12.25 № 31-1/169
танай _____-ны № _____-т

Тогтоолын төсөл өргөн мэдүүлэх
тухай

“Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх тухай хэлэлцээрийг байгуулахад баримтлах чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1 дэх хэсэгт заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

900244002397



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2024.12.25 № ХЯТ/2680
танай _____-ны № _____-т

Тогтоолын төсөл өргөн мэдүүлэх
хугацаа товлох тухай

“Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх тухай хэлэлцээрийг байгуулахад баримтлах чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1 дэх хэсэгт заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт 21 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Н.УЧРАЛ

000245021060



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>

2004.12.24 № 01/10621

танай _____-ны № _____-т

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН САЙД Ц.ТУВААН ТАНАА

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд хилийн Гашуунсухайт-Ганцмод боомт дахь хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх тухай хэлэлцээрийг байгуулахад баримтлах чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг үүгээр олгож байна.

Хүндэтгэсэн,



Б.ЖАВХЛАН



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,

Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,


Цахим хуудас: www.mojha.gov.mn

2024. 12. 25 № 11/2570

танай _____-ны № _____-т

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН САЙД Ц.ТУВААН ТАНАА

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд хилийн Гашуунсухайт Ганцмод боомт дахь хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх тухай хэлэлцээрийн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 19¹ дүгээр зүйлийн 19^{1.1} дэх хэсэгт зааснаар Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагыг хангасан байна.



О.АЛТАНГЭРЭЛ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,


Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2024.12.25 № 1/1571
танай _____-ны № 01/1409 -т

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН САЙД Ц.ТУВААН ТАНАА

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд хилийн Гашуунсухайт Ганцмод боомт дахь хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх тухай хэлэлцээрийн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



О.АЛТАНГЭРЭЛ

15180054026

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны 46 дугаар тэмдэглэлд:

“З.ХЭЛЭЛЦСЭН нь: “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх тухай хэлэлцээрийг байгуулахад баримтлах чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх тухай хэлэлцээрийг байгуулахад баримтлах чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1 дэх хэсэгт заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



“МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНД ГАШУУНСУХАЙТ-ГАНЦМОД БООМТЫН ХИЛ ДАМНАСАН ТӨМӨР ЗАМЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭРИЙГ БАЙГУУЛАХАД БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Тогтоолын төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага:

Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ” гэж, Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 9-д “Улсын Их Хуралтай зөвшилцөж дараа соёрхон батлуулахаар Монгол Улсын олон улсын гэрээ байгуулах, хэрэгжүүлэх, түүнчлэн Засгийн газар хоорондын гэрээ байгуулах, цуцлах” гэж тус тус заасан.

Олон Улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “Улсын Их Хурал дараахь олон улсын гэрээг заавал соёрхон батална” гэж, мөн зүйлийн 8.1.3 дахь заалтад “Монгол Улсын хуульд зааснаас өөр журам тогтоож байгаа, эсхүл тухайн гэрээг байгуулснаар, нэгдсэнээр, эсхүл хэрэгжүүлснээр Монгол Улсын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл хууль шинээр батлах шаардлагатай олон улсын гэрээ” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т бодлогын үндсэн 4 чиглэлийн хүрээнд 14 мега төслийг хэрэгжүүлэхээр тусгасны нэгдүгээрт “Гашуунсухайт-Ганцмод, Ханги-Мандал, Шивээхүрэн-Сэхээ хилийн боомтуудын хил дамнасан холболтын төмөр зам, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминалыг барина гэж тусгасан. Тус төслийг хэрэгжүүлснээр нийт экспортын хүчин чадал 40 сая тонноор буюу Гашуунсухайт-Ганцмод боомт 20 сая тонн, Ханги-Мандал боомт 10 сая тонн, Шивээхүрэн-Сэхээ боомт 10 сая тонноор нэмэгдэж, экспортын орлого 2 дахин, төмөр замаар нүүрс экспортлох хүчин чадал 3 дахин, зорчигч болон ачаа тээврийн нэвтрэх хүчин чадал 2 дахин нэмэгдэж, тээврийн хэрэгсэл хилийн боомтоор түргэн шуурхай нэвтрэх, зорчигчид ая тухтай үйлчлүүлэх боломж бүрдэнэ”, 3.3.1.1-д “Уул уурхайн салбарын түүхий эдийн боловсруулалтын түвшин болон хүнд үйлдвэрлэлийн хүчин чадлыг өсгөж, экспортын орлогыг нэмэгдүүлнэ”, 3.3.2.2. Хил дамнасан төмөр замын холболтыг барьж, хилийн боомтуудыг хатуу хучилттай авто замаар холбож, ачаа тээврийн терминалуудыг байгуулж, уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг жилд 100.0 сая тоннд хүргэнэ” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод “Стратегийн орд газруудыг хилийн боомттой холбосон төмөр замуудыг барьж, байгуулна.” гэж, “Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно.” гэж, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шат болох Боомтын сэргэлтийн хүрээнд “Хилийн боомтуудыг төмөр зам болон хатуу хучилттай авто замаар үе шаттайгаар бүрэн холбон, тээвэр, логистикийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн ачаа тээврийн урсгалыг сайжруулж, цаашид транзит улс болох суурь нөхцөлийг бүрдүүлнэ” гэж тус тус заасан.

Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын 2004 оны “Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай” хэлэлцээрийн дагуу Монгол-Хятадын хилийн хэсэгт Шивээхүрэн-Сэхээ, Гашуунсухайт-Ганцмод, Замын-Үүд-Эрээн, Бичигт-Зүүнхатавч хилийн боомтуудад төмөр замын хилийн боомт ажиллахаар тогтсон. Дээрх хэлэлцээрийн дагуу Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талаас Ганцмод, Сэхээ, Зүүнхатавч боомтууд хүртэлх төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг хийж дуусгасан бөгөөд Монгол Улсын төмөр замтай холбогдоход бэлэн болсон. Харин Монгол Улсын талаас хэлэлцээр байгуулагдсанаас хойш төмөр замын хилийн холболт, боомтын бүтээн байгуулалтын ажлууд хэрэгжээгүй байна.

Иймд Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Урт хугацааны бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050” болон дээр дурдсан хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх тухай хэлэлцээрийг байгуулахад баримтлах чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулна.

Хоёр.Тогтоолын төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ:

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх тухай Засгийн газар хооронд хэлэлцээр байгуулах чиглэлээр хэлэлцээ хийх үедээ баримтлах чиглэлийг тусгах болно. Үүнд:

1/ Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хооронд төрийн дээд, өндөр түвшинд тохирсон иж бүрэн хамтын ажиллагааны хүрээнд аливаа гуравдагч талын оролцоогүйгээр хэрэгжүүлэх;

2/ Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын эдийн засгийн үр ашгийг хангах зорилгоор төмөр замын бүтээн байгуулалт, нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээг байгуулах, уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх гурван асуудлыг харилцан уялдаатай цогц байдлаар хамтад нь шийдвэрлэх;

3/ Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын хүрээнд уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагаанд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцаа, эзэмшиж байгаа ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг бусад этгээдэд шилжүүлэхгүй байх;

4/ Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн төмөр замын тээврийн багтаамж, эдийн засгийн үр өгөөжийг хангах зорилгоор нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээний үнийг тогтоохдоо “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн урт хугацаатай байгуулсан гэрээний нөхцөл, үнийн аргачлалыг жишиг болгож, гэрээний хугацааг хэлэлцээ хийж эхэлсэн хугацаатай уялдуулан 16 хүртэл жилээр тогтоох;

5/ Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн төмөр замын тээврийн хүчин чадал, эдийн засгийн үр өгөөжийг хангах зорилгоор нүүрс худалдах, худалдан авах гэрээний дагуу нийлүүлэх нүүрсний хэмжээг 2025-2029 онд нийт 27 сая тонн, 2030 оноос эхлэн жилд 20 сая тонноос бууруулахгүй байх;

6/ Хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замыг байгуулахад өргөн, нарийн царигийн аливаа маргаан дахин үүсэхгүйг бататгах;

7/ Хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтад “Нэг зураг төсөлтэй, нэг гүйцэтгэгчтэй, бүтээн байгуулалтыг зэрэг эхлүүлж, зэрэг дуусгах” зарчим баримтлах;

8/ Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам барих, түүнийг холбох бүтээн байгуулалтын төслийн ажлыг хятадын талын сонгон шалгаруулсан аж ахуйн нэгжээр төмөр зам, түүнийг холбох барилга байгууламжийг гүйцэтгүүлэн хамтран ажиллах;

9/ Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хил доторх Ганцмод боомт хүртэлх баригдсан төмөр замын бүтээн байгуулалттай холбогдуулж өнгөрсөн хугацаанд хятадын талд гарсан аливаа алдагдал, хохирол болон төмөр замын хил холболтод шаардлагатай хөрөнгө оруулалтын асуудлыг ирээдүйд нэхэмжлүүлэхгүй байх;

10/ Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг эхлүүлснээр Монгол, Хятадын хилийн Шивээхүрэн-Сэхээ, Ханги-Мандал, Бичигт-Зүүнхатавч зэрэг боомтуудыг төмөр замаар холбох ажлыг үе шаттайгаар эхлүүлэх тохиролцоонд хүрэх;

11/ Сэргээгдэх эрчим хүчний экспорт, эрчим хүчний нүүрс экспортлох, нүүрсийг гүн боловсруулах аж үйлдвэржилт, говийг усжуулах, шар шороон шуурга, цөлжилттэй тэмцэх, хил холболт болон дэд бүтцийн бүтээн байгуулалт, орон сууцжуулалтын асуудалд харилцан ашигтай хамтран ажиллах зэрэг болно.

Гурав. Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал:

Тогтоолын төсөл батлагдсанаар Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх тухай Засгийн газар хооронд хэлэлцээр байгуулах чиглэлээр хэлэлцээ хийх үедээ баримтлах чиглэл тодорхой болох боломж бүрдэнэ.

Дөрөв. Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал:

Тогтоолын төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцүүлэн боловсруулна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан нэмэлт, өөрчлөлт оруулах хууль тогтоомжийн төсөл байхгүй болно.

-ooOoo-

ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т бодлогын үндсэн 4 чиглэлийн хүрээнд 14 мега төслийг хэрэгжүүлэхээр тусгасны нэгдүгээрт “Гашуунсухайт-Ганцмод, Ханги-Мандал, Шивээхүрэн-Сэхээ хилийн боомтуудын хил дамнасан холболтын төмөр зам, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминалыг барина гэж тусгасан. Тус төслийг хэрэгжүүлснээр нийт экспортын хүчин чадал 40 сая тонноор буюу Гашуунсухайт-Ганцмод боомт 20 сая тонн, Ханги-Мандал боомт 10 сая тонн, Шивээхүрэн-Сэхээ боомт 10 сая тонноор нэмэгдэж, экспортын орлого 2 дахин, төмөр замаар нүүрс экспортлох хүчин чадал 3 дахин, зорчигч болон ачаа тээврийн нэвтрэх хүчин чадал 2 дахин нэмэгдэж, тээврийн хэрэгсэл хилийн боомтоор түргэн шуурхай нэвтрэх, зорчигчид ая тухтай үйлчлүүлэх боломж бүрдэнэ”, 3.3.1.1-д “Уул уурхайн салбарын түүхий эдийн боловсруулалтын түвшин болон хүнд үйлдвэрлэлийн хүчин чадлыг өсгөж, экспортын орлогыг нэмэгдүүлнэ”, 3.3.2.2. Хил дамнасан төмөр замын холболтыг барьж, хилийн боомтуудыг хатуу хучилттай авто замаар холбож, ачаа тээврийн терминалуудыг байгуулж, уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг жилд 100.0 сая тоннд хүргэнэ” гэж тус тус заасан.

Уг хил дамнасан төмөр замыг бүтээн байгуулснаар Монгол Улс, БНХАУ хоорондын худалдаа, эдийн засаг, бүс нутгийн хамтын ажиллагаа, эрдэс баялаг, аж үйлдвэр, дэд бүтцийн салбарын хамтын ажиллагаа идэвхжиж, улмаар Шивээхүрэн-Сэхээ, Ханги-Мандал, Бичигт-Зүүнхатавч боомтуудыг төмөр замаар холбох нөхцөл бүрдэх бөгөөд хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадал 2030 оноос 80 сая тонноор нэмэгдэх стратегийн ач холбогдолтой юм.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар Монгол, Хятадын Гашуунсухайт-Ганцмод боомтын хил холболтын төмөр замын бүтээн байгуулалтын талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар хэлэлцэж, “1955 оны “Монгол, Хятадын хилийн төмөр замын хэлэлцээр” болон “Гашуунсухайт-Ганцмод” хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай” 68 дугаар тогтоолыг баталсан.

Улмаар Монгол Улсын Ерөнхий Сайдын 2024 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 28 дугаар Захирамжаар “1955 оны “Монгол, Хятадын хилийн төмөр замын хэлэлцээр” болон “Гашуунсухайт-Ганцмод” хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай” 68 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдаар ахлуулан ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан тэргүүтэй төлөөлөгчид Хятадын талтай өндөр түвшний уулзалтуудыг удаа дараа хийсэн бөгөөд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын “Чайна Энержи Групп”-ээс тогтвортой хууль эрх зүйн орчин, гэрээг хэрэгжүүлэх нөхцлийг баталгаатай байлгах, урт хугацааны худалдааны гэрээ, нүүрсний ордын хүчин чадлыг нэмэгдүүлэх болон төмөр замын холболтын талаар хэд хэдэн тодорхой саналыг тавьсан.

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх тухай Засгийн газар хооронд хэлэлцээр байгуулах чиглэлээр хэлэлцээ хийх үедээ баримтлах чиглэлийг тусгах болно. Үүнд:

1/ Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хооронд төрийн дээд, өндөр түвшинд тохирсон иж бүрэн хамтын ажиллагааны хүрээнд аливаа гуравдагч талын оролцоогүйгээр хэрэгжүүлэх;

2/ Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын эдийн засгийн үр ашгийг хангах зорилгоор төмөр замын бүтээн байгуулалт, нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээг байгуулах, уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх гурван асуудлыг харилцан уялдаатай цогц байдлаар хамтад нь шийдвэрлэх;

3/ Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын хүрээнд уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагаанд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцаа, эзэмшиж байгаа ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг бусад этгээдэд шилжүүлэхгүй байх;

4/ Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн төмөр замын тээврийн багтаамж, эдийн засгийн үр өгөөжийг хангах зорилгоор нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээний үнийг тогтоохдоо “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн урт хугацаатай байгуулсан гэрээний нөхцөл, үнийн аргачлалыг жишиг болгож, гэрээний хугацааг хэлэлцээ хийж эхэлсэн хугацаатай уялдуулан 16 хүртэл жилээр тогтоох;

5/ Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн төмөр замын тээврийн хүчин чадал, эдийн засгийн үр өгөөжийг хангах зорилгоор нүүрс худалдах, худалдан авах гэрээний дагуу нийлүүлэх нүүрсний хэмжээг 2025-2029 онд нийт 27 сая тонн, 2030 оноос эхлэн жилд 20 сая тонноос бууруулахгүй байх;

6/ Хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замыг байгуулахад өргөн, нарийн царигийн аливаа маргаан дахин үүсэхгүйг бататгах;

7/ Хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтад “Нэг зураг төсөлтэй, нэг гүйцэтгэгчтэй, бүтээн байгуулалтыг зэрэг эхлүүлж, зэрэг дуусгах” зарчим баримтлах;

8/ Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам барих, түүнийг холбох бүтээн байгуулалтын төслийн ажлыг хятадын талын сонгон шалгаруулсан аж ахуйн нэгжээр төмөр зам, түүнийг холбох барилга байгууламжийг гүйцэтгүүлэн хамтран ажиллах;

9/ Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хил доторх Ганцмод боомт хүртэл баригдсан төмөр замын бүтээн байгуулалттай холбогдуулж өнгөрсөн хугацаанд хятадын талд гарсан аливаа алдагдал, хохирол болон төмөр замын хил холболтод шаардлагатай хөрөнгө оруулалтын асуудлыг ирээдүйд нэхэмжлүүлэхгүй байх;

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

“Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх тухай хэлэлцээрийг байгуулахад баримтлах чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ” гэж, Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 9-д “Улсын Их Хуралтай зөвшилцөж дараа соёрхон батлуулахаар Монгол Улсын олон улсын гэрээ байгуулах, хэрэгжүүлэх, түүнчлэн Засгийн газар хоорондын гэрээ байгуулах, цуцлах” гэж тус тус заасан.

Олон Улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “Улсын Их Хурал дараахь олон улсын гэрээг заавал соёрхон батална” гэж, мөн зүйлийн 8.1.3 дахь заалтад “Монгол Улсын хуульд зааснаас өөр журам тогтоож байгаа, эсхүл тухайн гэрээг байгуулснаар, нэгдсэнээр, эсхүл хэрэгжүүлснээр Монгол Улсын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл хууль шинээр батлах шаардлагатай олон улсын гэрээ” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т бодлогын үндсэн 4 чиглэлийн хүрээнд 14 мега төслийг хэрэгжүүлэхээр тусгасны нэгдүгээрт “Гашуунсухайт-Ганцмод, Ханги-Мандал, Шивээхүрэн-Сэхээ хилийн боомтуудын хил дамнасан холболтын төмөр зам, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминалыг барина гэж тусгасан. Тус төслийг хэрэгжүүлснээр нийт экспортын хүчин чадал 40 сая тонноор буюу Гашуунсухайт-Ганцмод боомт 20 сая тонн, Ханги-Мандал боомт 10 сая тонн, Шивээхүрэн-Сэхээ боомт 10 сая тонноор нэмэгдэж, экспортын орлого 2 дахин, төмөр замаар нүүрс экспортлох хүчин чадал 3 дахин, зорчигч болон ачаа тээврийн нэвтрэх хүчин чадал 2 дахин нэмэгдэж, тээврийн хэрэгсэл хилийн боомтоор түргэн шуурхай нэвтрэх, зорчигчид ая тухтай үйлчлүүлэх боломж бүрдэнэ”, 3.3.1.1-д “Уул уурхайн салбарын түүхий эдийн боловсруулалтын түвшин болон хүнд үйлдвэрлэлийн хүчин чадлыг өсгөж, экспортын орлогыг нэмэгдүүлнэ”, 3.3.2.2. Хил дамнасан төмөр замын холболтыг барьж, хилийн боомтуудыг хатуу хучилттай авто замаар холбож, ачаа тээврийн терминалуудыг байгуулж, уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг жилд 100.0 сая тоннд хүргэнэ” гэж тус тус заасан.

Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан арга хэмжээг авч хэрэгжүүлэх, Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, “Гашуунсухайт-Ганцмод” хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Тогтоолын төсөлд тусгасан арга хэмжээний үндэслэл, шаардлагын тухайд:

1/ Монгол, Хятадын Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хооронд төрийн дээд, өндөр түвшинд тохирсон иж бүрэн хамтын ажиллагааны хүрээнд аливаа гуравдагч талын оролцоогүйгээр хэрэгжүүлэх:

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын “Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай” хэлэлцээрийг 2004 онд байгуулсан. Энэхүү хэлэлцээрийн дагуу Монгол-Хятадын хилийн хэсэгт Шивээхүрэн-Сэхээ, Гашуунсухайт-Ганцмод, Замын-Үүд-Эрээн, Бичигт-Зүүнхатавч хилийн боомтуудад төмөр замын хилийн боомт ажиллахаар тогтсон.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талаас Ганцмод, Сэхээ, Зүүнхатавч боомтууд хүртэлх төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг хийж дуусгасан бөгөөд Монгол Улсын төмөр замтай холбогдоход бэлэн болсон. Харин Монгол Улсын талаас хэлэлцээр байгуулагдсанаас хойш төмөр замын хилийн холболт, боомтын бүтээн байгуулалтын ажлууд хэрэгжээгүй байна. Тодруулбал, Монгол Улсын Засгийн газар нь дээрх хилийн боомтуудад төмөр замын хилийн боомт ажиллуулах Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ өнөөдрийг хүртэл биелүүлээгүй байна.

Мөн энэ асуудлаар Монгол Улсын Ерөнхий сайдын 2013 онд Бүгд Найрамдах Хятад Ард Улсад хийсэн айлчлал болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын даргын 2014 онд Монгол Улсад хийсэн дээд хэмжээний айлчлалын үеэр хэлэлцэж, албан ёсны хэлэлцээрт тусгахаас гадна тусгайлсан баримт бичгүүд байгуулж байсан.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн¹ Аравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.” гэж заасныг хэрэгжүүлэх хүрээнд тус зохицуулалтыг тусгалаа.

2/ Монгол, Хятадын Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын эдийн засгийн үр ашгийг хангах зорилгоор төмөр замын бүтээн байгуулалт, нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээг байгуулах, уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх гурван асуудлыг харилцан уялдаатай цогц байдлаар хамтад нь шийдвэрлэх:

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд 2009 онд байгуулсан “Эрдэс баялаг, эрчим хүчний салбарт хамтран ажиллах тухай БНХАУ-ын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн 2.2-т “Хоёр улсын эрдэс баялаг, эрчим хүчний салбарын төсөл, түүнтэй холбогдох дэд бүтцийн томоохон төслүүдийг хамтран дэмжинэ” гэж тусгасан.

Хамтын ажиллагааны явцад гарч буй асуудлыг зохицуулах, талуудын аж ахуйн нэгжүүдийн хууль ёсны эрх ашгийг хамгаална” гэж, 2013 оны “Монгол улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хооронд стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх дунд, урт хугацааны хөтөлбөр”-ийн 3 дугаар бүлгийн 1.1-т “Талууд уул уурхайн баялгийг нээн олборлох, дэд бүтцийн бүтээн байгуулалт, санхүүгийн хамтын ажиллагаа зэргийг уялдуулан цогц байдлаар хөгжүүлэх худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны ерөнхий үзэл санааны дагуу эрх тэгш зөвлөлдөх, харилцан ашигтай, хамтдаа хожих зарчмыг баримтлан Монгол, Хятадын худалдаа, эдийн засгийн бодит хамтын ажиллагааг бүх талаар гүнзгийрүүлэхээр санал нэгтэй тохиролцов” гэж, 2014 оны “Монгол Улс, БНХАУ-ын хооронд иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлэх тухай хамтарсан тунхаглал”-ын 2-т. “...Талууд эрдэс баялгийг нээн олборлох, дэд бүтцийг бүтээн байгуулалт, санхүүгийн хамтын

¹ Төрийн мэдээдэл эмхэтгэл (1992), №1

ажиллагааг уялдуулан цогц байдлаар хөгжүүлэх зарчмын дагуу бүх талын харилцан ашигтай хамтын ажиллагааг өрнүүлнэ...” гэж тус тус туссан.

Иймд Тавантолгой-Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн төмөр замын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, тээвэрлэлтийн хүчин чадлыг бүрэн ашиглах зорилгоор нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээг байгуулах, уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлж, төмөр замаар тээвэрлэх ачааг баталгаажуулах шаардлага үүсээд байна.

Гашуунсухайт-Ганцмод боомтоор дамжин өнгөрөх тээврийг үр ашигтай, байгаль орчинд ээлтэй авто зам, төмөр зам хосолсон логистикийн төвийн үйлчилгээний горимд шилжүүлэх ажлыг хурдасгаснаар логистикийн зардлыг бууруулах, боомтын тээврийн үр ашгийг дээшлүүлэх Тавантолгойн уурхайн олборлолтын талбайн төлөвлөсөн үйлдвэрлэлийн хүчин чадлыг жилд 80 сая тонн хүргэх, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын нутаг дэвсгэрт төмөр замаар бусад бүс нутаг руу тээвэрлэлт хийх боломж бүрдэх бөгөөд бүс нутгийн нүүрсний тээврийн хэрэгцээг хангахад чухал ач холбогдолтой юм.

Хил дамнасан төмөр зам ашиглалтад орохоос өмнө нүүрс худалдах, худалдан авах урьдчилгаа төлбөрийн нөхцөлтэй урт хугацаатай гэрээ байгуулах ба энэ гэрээний хүрээнд “Эрдэнэс Тавантолгой” ХК 2025-2029 онд нийт 27 сая тонн, 2030 оноос эхлэн жилд 20 сая тонн нүүрс нийлүүлж, хоёр улс төмөр замаар холбогдсоны үр ашгийг хүртэхээр байна. ;

Харин хил дамнасан төмөр зам ашиглалтад орсны дараа жил бүр 20 сая тонноос доошгүй нүүрс нийлүүлэхийн тулд ордын үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлагатай бөгөөд энэ хамтын ажиллагааг мөн шийдвэрлэхээр хэлэлцээ хийх юм

3/ Монгол, Хятадын Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын хүрээнд уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагаанд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцаа, эзэмшиж байгаа ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг бусад этгээдэд шилжүүлэхгүй байх:

“Эрдэнэс Тавантолгой” ХК нь Тавантолгойн нүүрсний бүлэг ордод ашиглалтын 8 тусгай зөвшөөрлийг эзэмшиж байгаа бөгөөд тогтоолын төсөлд тус компанийн эзэмшиж байгаа ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүдийг бусад этгээдэд шилжүүлэхгүй байх талаар тусгалаа. Өөрөөр хэлбэл, тус компанийн өмчлөл болон хувьцаа эзэмшилд аливаа өөрчлөлтийг оруулахгүй байх чиглэлийг хэлэлцээний явцад баримтлахаар тусгав.

4/ Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн төмөр замын тээврийн багтаамж, эдийн засгийн үр өгөөжийг хангах зорилгоор нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээний үнийг тогтоохдоо “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн урт хугацаатай байгуулсан гэрээний нөхцөл, үнийн аргачлалыг жишиг болгож, гэрээний хугацааг хэлэлцээ хийж эхэлсэн хугацаатай уялдуулан 16 хүртэл жилээр тогтоох:

Монгол, Хятадын Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн төмөр замын төсөл 2003 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн Монгол, Хятадын худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны асуудлыг хэлэлцдэг гол механизм болсон Монгол, Хятадын Засгийн газар хоорондын хамтарсан комиссын хуралдаанд манай талаас

Тавантолгойн нүүрсний ордыг цогцолбор байдлаар ашиглах төслийг санал болгосон нь Протоколд тусгагдсанаар эхэлж байсан түүхтэй.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талаас дээр дурдсан хугацаанаас эхлэн хамтын ажиллагаа эхэлсэн гэж үзэж нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээний хугацааг 20 жилээр байгуулах саналыг тавьсан.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн 2024 оны 10 дугаар сарын 14-нд Бүгд Найрамдах Хятад Ард Улсад хийсэн айлчлалын хүрээнд хийсэн уулзалтын үр дүнд дээрх хугацааг 16 жил болгож бууруулсан.

“Эрдэнэс Тавантолгой” ХК 2011 оноос эхлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгжүүдтэй урт хугацаатай нүүрсний худалдааны гэрээг байгуулж ирсэн бөгөөд гэрээг байгуулахдаа тодорхой аргачлалын дагуу үнийг тогтоох жишгийг хэрэглэж ирсэн.

Монгол, Хятадын Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын хүрээнд байгуулах нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээний үнийн аргачлалыг дээр дурдсан жишгийг баримтлахыг санал болгосон.

5/ Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн төмөр замын тээврийн хүчин чадал, эдийн засгийн үр өгөөжийг хангах зорилгоор нүүрс худалдах, худалдан авах гэрээний дагуу нийлүүлэх нүүрсний хэмжээг 2025-2029 онд нийт 27 сая тонн, 2030 оноос эхлэн жилд 20 сая тонноос бууруулахгүй байх;

“Эрдэнэс Тавантолгой” ХК өнөөгийн байдлаар жилд дунджаар 30.0 орчим сая тонн нүүрс олборлож байна. Үүнтэй холбоотойгоор хил холболтын төмөр замын бүтээн байгуулалт болон уурхайн олборлолтын хүчин чадлыг нэмэх хүртэлх хугацаанд жилийн 5-6 сая тонн нүүрсийг дээр дурдсан гэрээний хүрээнд нийлүүлэх боломжтой байна.

Цаашид хил холболтын төмөр зам ашиглалтад Монгол Улсын нүүрсний нийт экспорт 120 орчим сая тоннд хүрэх бөгөөд үүнээс жил бүр 20 сая тонн нүүрсийг хоёр Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд нийлүүлэх боломж бүрдэхээр байна.

6/ Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замыг байгуулахад өргөн, нарийн царигийн аливаа маргаан дахин үүсэхгүйг бататгах:

Төмөр замын царигийн өргөн 2008 оноос 2020 оны хооронд 4 удаа өөрчлөгдсөн. Тухайлбал:

“Энержи Ресурс” ХХК 2008 онд Ухаахудаг-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ийг нарийн царигтайгаар боловсруулсан.

Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолоор “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ыг баталж, “бүтээгдэхүүн нь экспортод шууд тээвэрлэгдэх хилийн боомтын төмөр замын шугамын царигийн өргөнийг Засгийн газар Улсын Их Хуралд танилцуулж шийдвэрлүүлэх”-ээр зохицуулсан байна.

Үүний дагуу Монгол улсын Засгийн газрын 2012 оны 161 дүгээр тогтоолын дагуу “Энержи Ресурс” ХХК-тай концессын гэрээ байгуулж, өргөн царигаар Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын барилгын ажлыг эхлүүлсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн урилгаар 2014 оны 08 дугаар сард БНХАУ-ын дарга Ши Жиньпин Монгол Улсад Төрийн айлчлал хийсэн. Айлчлалын үеэр БНХАУ-ын дарга Ши Жиньпин: хэрэв Монгол Улс өмнөд чиглэлийн төмөр замыг нарийн царигаар барьж байгуулсан тохиолдолд Хятадын тал санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд бэлэн болохоо илэрхийлсэн.

Иймд УИХ-ын 2014 оны 64 дүгээр тогтоолоор Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замыг нарийн царигаар барихаар шийдвэрлэсэн бөгөөд энэ үеэс “Монголын Төмөр Зам” ТӨХК-ийн хариуцан гүйцэтгэж байсан өргөн царигийн төмөр замын барилгын ажил зогссон байна.

Үндсэн хуулийн цэцээс УИХ-ын 2014 оны 64 дүгээр тогтоол нь хууль зөрчсөн тухай 2020 оны 04 дүгээр дүгнэлт гаргаснаар тус тогтоолыг хүчингүй болгож, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замыг өргөн царигтай барьж байгуулахаар барилгын ажлыг эхлүүлсэн байна.

2014 онд нарийн царигтай төмөр зам барих тохирооноос монголын тал ухарч өргөн царигтай байх талаар Улсын Их Хурал шийдвэрлэснээс шалтгаалан хятадын талд нэмэлт хөрөнгө оруулалт хийх шаардлагатай гэсэн байр суурийг хятадын талаас удаа дараа илэрхийлж ирсэн.

БНХАУ-ын “Чайна энерги групп” компаниас 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдөр “хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалт, нүүрсний худалдаа, нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааг цогцоор шийдвэрлэх тухай хүсэлт”-ийг ирүүлсэн.

Тус хүсэлтэд Хятадын тал нь боомтын төмөр зам барьсан хөрөнгө оруулалт 7,17 тэрбум юань, 10 жилийн хугацааны алдагдал 2.7 тэрбум; цаашид шаардлагатай нэмэлт хөрөнгө оруулалт 4.1 тэрбум юань зэрэг нийтдээ 13,97 орчим тэрбум юанийн алдагдал хүлээгээд байгаа талаар албан бичигт тусгасан байна.

Үүнтэй холбогдуулан Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талд тус төсөлтэй холбоотой царигийн маргаан дахин үүсэхгүй байхыг бататгах зорилгоор энэхүү заалтыг тусгалаа.

7/ Хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтад “Нэг зураг төсөлтэй, нэг гүйцэтгэгчтэй, бүтээн байгуулалтыг зэрэг эхлүүлж, зэрэг дуусгах” зарчим баримтлах:

Гашуунсухайт-Ганцмод төмөр замын төслийн төсөвт өртөг нарийвчилсан зураг төслийн дагуу урьдчилсан тооцооллоор 979 тэрбум төгрөг байхаар тооцоологдож байгаа бөгөөд санхүүжилтийн асуудлыг УИХ-ын 2023 оны 68 дугаар тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой” ХК хариуцахаар шийдвэрлэгдсэн. Одоогоор төмөр замын төслийн ТЭЗҮ, зураг төсөл хийгдэж дууссан, барилгын ажлын гэрээний төслийг компанийн хэмжээнд тохироод байгаа болно.

Ганцмод хил дамнасан төмөр зам нь 1-р зэрэглэлийн, 1520 мм өргөн цариг, 1435 мм нарийн царигийн хос замтай, гол замын урт 19,5 км, өргөн царигаар жилд 30 сая.тн, нарийн царигаар жилд 10 сая.тн ачаа тээвэрлэх хүчин чадалтай болно.

Тус хил холболтын бүтээн байгуулалтын ажлын технологит хугацаа нь 24 сар байх тул барилга угсралтын ажлыг нэн яаралтай эхлүүлэх шаардлага тулгараад байгаа тул энэхүү заалтыг тусгасан.

8/ Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам барих, түүнийг холбох бүтээн байгуулалтын төслийн ажлыг хятадын талын сонгон шалгаруулсан аж ахуйн нэгжээр төмөр зам, түүнийг холбох барилга байгууламжийг гүйцэтгүүлэн хамтран ажиллах:

Улсын Их Хурлын 2023 оны 68 дугаар тогтоолын 1 дэх хэсгийн 3-т "Гашуунсухайт-Ганцмод" хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг зураг төслийн дагуу Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хил доторх "Ганцмод" боомт хүртэлх төмөр замын суурь бүтэц эзэмшигч төрийн өмчит компаниар гүйцэтгүүлж, холбогдох зардлыг "Эрдэнэс Тавантолгой" ХК-иас санхүүжүүлэх" гэж заасан.

Гэвч Хятадын талын төслийн гүйцэтгэгч, суурь бүтэц эзэмшигч компанийг өөрчлөн шинээр төслийн зориулалттай компани байгуулж, түүнд суурь бүтэц эзэмшигчээс бусад эрхийг шилжүүлсэн талаар 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдөр хятадын талын ажлын хэсгийн ахлагч Кан Фэнвэй-ээс монголын талын ажлын хэсгийн ахлагч Д.Амарбаясгаланд албан захидлаар мэдэгдсэн. Хятадын тал дотооддоо сонгон шалгаруулалт хийж гүйцэтгэгч байгууллагыг тодорхойлж, монголын талын бүтээн байгуулалтыг тус байгууллагаар гүйцэтгүүлэх талаар мэдэгдсэн.

9/ Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хил доторх Ганцмод боомт хүртэлх баригдсан төмөр замын бүтээн байгуулалттай холбогдуулж өнгөрсөн хугацаанд хятадын талд гарсан аливаа алдагдал, хохирол болон төмөр замын хил холболтод шаардлагатай хөрөнгө оруулалтын асуудлыг ирээдүйд нэхэмжлүүлэхгүй байх:

БНХАУ-ын Чайна энерги групп компаниас "хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалт, нүүрсний худалдаа, нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааг цогцоор шийдвэрлэх тухай хүсэлт"-ийг тавьсан бөгөөд тус хүсэлтэд Хятадын тал нь боомтын төмөр зам барьсан хөрөнгө оруулалт 7,17 тэрбум юань, 10 жилийн хугацааны алдагдал 2.7 тэрбум, цаашид шаардлагатай нэмэлт хөрөнгө оруулалт 4.1 тэрбум юань зэрэг нийтдээ 13,97 орчим тэрбум юанийн алдагдал хүлээгээд байгаа талаар мэдэгдсэн.

Үүнтэй холбогдуулан Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талд энэхүү төсөлтэй холбогдон гарсан аливаа алдагдал, хохирол болон төмөр замын хил холболтод шаардлагатай хөрөнгө оруулалтын асуудлыг ирээдүйд нэхэмжлүүлэхгүй байхаар хэлэлцээ хийх талаар тусгалаа.

10/ Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг эхлүүлснээр Монгол, Хятадын хилийн Шивээхүрэн-Сэхээ, Ханги-Мандал, Бичигт-Зүүнхатавч зэрэг боомтуудыг төмөр замаар холбох ажлыг үе шаттайгаар эхлүүлэх тохиролцоонд хүрэх:

Хятадын талаас эхний ээлжид Гашуунсухайт-Ганцмод боомтын төмөр замыг барьж, ашиглалтад оруулсны дараа нөхцөл нь бүрдсэн бусад боомтуудыг төмөр замаар холбох байр суурийг байнга илэрхийлсээр ирсэн. Тухайлбал, 2022.11.28-нд БНХАУ-ын Гадаад хэргийн сайд: "Хөгжил, шинэчлэлийн хорооны одоогийн байр

суурь бол Гашуунсухайт-Ганцмод боомтын төмөр замыг эхний ээлжид дуусгахад анхаарч байна” гэдгээ илэрхийлсэн.

Иймд бусад хил холболтын төмөр замын төслүүдийг эхлүүлэх ажлыг баталгаажуулах зорилгоор энэхүү заалтыг тусгасан.

11/ Сэргээгдэх эрчим хүчний экспорт, эрчим хүчний нүүрс экспортлох, нүүрсийг гүн боловсруулах аж үйлдвэржилт, говийг усжуулах, шар шороон шуурга, цөлжилттэй тэмцэх, хил холболт болон дэд бүтцийн бүтээн байгуулалт, орон сууцжуулалтын асуудалд харилцан ашигтай хамтран ажиллах:

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, эрчим хүчний нүүрс экспортлох, нүүрсийг гүн боловсруулах, говийг усжуулах, шар шороон шуурга, цөлжилттэй тэмцэх, хил холболт болон дэд бүтцийн бүтээн байгуулалт, орон сууцжуулалтын төслүүдийг хэрэгжүүлэх талаар тусгасан.

Эдгээр арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд Үндэсний баялгийн сан гол нөлөөг үзүүлэх бөгөөд стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн нүүрсний ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой.

Нөгөөтэйгүүр, дээр дурдсан томоохон төслүүдийг хэрэгжүүлэхэд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын туршлага, техник, технологи болон хөрөнгө оруулалтын хамтын ажиллагаа чухал байна.

Улсын Их Хурлын тогтоолын төсөл батлагдсанаар Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын хэлэлцээр байгуулснаар төмөр замаар экспортлох ачааны хэмжээг жилд 30 сая.тн түүнээс дээш, Тавантолгойн ордын нүүрсний экспортын хэмжээг жилд 70 сая.тн хүртэл өсгөж, нүүрс борлуулалтын орлогыг жилд 1,5 тэрбум доллароор нэмэгдүүлэх боломж бүрдэхээр байна.

Мөн Монгол, Хятад хоёр улсын төрийн тэргүүн нарын 2014 онд баталсан “Монгол Улс, БНХАУ-ын хооронд иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлэх тухай хамтарсан тунхаглал” хэрэгжих нөхцөл бүрдэнэ. Тус тунхаглал хэрэгжсэнээр Монгол Улс, БНХАУ хоорондын худалдаа, эдийн засаг, боловсрол, эрүүл мэнд, соёл, хүмүүнлэгийн салбар, олон улс бүс нутгийн хамтын ажиллагаа, Эрдэс баялаг, Аж үйлдвэр, Дэд бүтцийн салбарын хамтын ажиллагаа идэвхжихээс гадна хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадал нэмэгдэх стратегийн ач холбогдолтой юм.

Цаашид эдийн засгийн өсөлт жил бүр 0.8 нэгж хувиар нэмэгдэх, ядуурлын түвшин буурч, нэг хүнд ногдох ДНБ-ийг 10000\$-т хүргэх, эдийн засгийн өсөлтийг 6%-аас дээш түвшинд хадгалах, инфляцыг 5%-д барих зэрэг эдийн засгийн томоохон ач холбогдолтой гэж үзэж байна.

Иймд Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх тухай Засгийн газар хооронд байгуулах хэлэлцээрийг хийх үедээ баримтлах чиглэл тодорхой болох боломж бүрдэх бөгөөд

тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1 дэх хэсэгт заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр бэлтгэлээ.

---oOo---

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

Дугаар

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНД ГАШУУНСУХАЙТ-ГАНЦМОД БООМТЫН ХИЛ
ДАМНАСАН ТӨМӨР ЗАМЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ХЭЛЭЛЦЭЭРИЙГ БАЙГУУЛАХАД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ БАТЛАХ
ТУХАЙ**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т туссан Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд хэлэлцээр байгуулах чиглэлээр хэлэлцээ хийхэд дараах үндсэн чиглэлийг баримталж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т зөвшөөрсүгэй:

1/ Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хооронд төрийн дээд, өндөр түвшинд тохирсон иж бүрэн хамтын ажиллагааны хүрээнд аливаа гуравдагч талын оролцоогүйгээр хэрэгжүүлэх;

2/ Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын эдийн засгийн үр ашгийг хангах зорилгоор төмөр замын бүтээн байгуулалт, нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээг байгуулах, уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх гурван асуудлыг харилцан уялдаатай цогц байдлаар хамтад нь шийдвэрлэх;

3/ Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын хүрээнд уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагаанд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцаа, эзэмшиж байгаа ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг бусад этгээдэд шилжүүлэхгүй байх;

4/ Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн төмөр замын тээврийн багтаамж, эдийн засгийн үр өгөөжийг хангах зорилгоор нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээний үнийг тогтоохдоо “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн урт хугацаатай байгуулсан гэрээний нөхцөл, үнийн аргачлалыг жишиг болгож, гэрээний хугацааг хэлэлцээ хийж эхэлсэн хугацаатай уялдуулан 16 хүртэл жилээр тогтоох;

5/ Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн төмөр замын тээврийн хүчин чадал, эдийн засгийн үр өгөөжийг хангах зорилгоор нүүрс худалдах, худалдан авах гэрээний дагуу нийлүүлэх нүүрсний хэмжээг 2025-2029 онд нийт 27 сая тонн, 2030 оноос эхлэн жилд 20 сая тонноос бууруулахгүй байх;

6/ Хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замыг байгуулахад өргөн, нарийн царигийн аливаа маргаан дахин үүсэхгүйг бататгах;

7/ Хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтад “Нэг зураг төсөлтэй, нэг гүйцэтгэгчтэй, бүтээн байгуулалтыг зэрэг эхлүүлж, зэрэг дуусгах” зарчим баримтлах;

8/ Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам барих, түүнийг холбох бүтээн байгуулалтын төслийн ажлыг хятадын талын сонгон шалгаруулсан аж ахуйн нэгжээр төмөр зам, түүнийг холбох барилга байгууламжийг гүйцэтгүүлэн хамтран ажиллах;

9/ Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хил доторх Ганцмод боомт хүртэл баригдсан төмөр замын бүтээн байгуулалттай холбогдуулж өнгөрсөн хугацаанд хятадын талд гарсан аливаа алдагдал, хохирол болон төмөр замын хил холболтод шаардлагатай хөрөнгө оруулалтын асуудлыг ирээдүйд нэхэмжлүүлэхгүй байх;

10/ Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг эхлүүлснээр Монгол, Хятадын хилийн Шивээхүрэн-Сэхээ, Ханги-Мандал, Бичигт-Зүүнхатавч зэрэг боомтуудыг төмөр замаар холбох ажлыг үе шаттайгаар эхлүүлэх тохиролцоонд хүрэх;

11/ Сэргээгдэх эрчим хүчний экспорт, эрчим хүчний нүүрс экспортлох, нүүрсийг гүн боловсруулах аж үйлдвэржилт, говийг усжуулах, шар шороон шуурга, цөлжилттэй тэмцэх, хил холболт болон дэд бүтцийн бүтээн байгуулалт, орон сууцжуулалтын асуудалд харилцан ашигтай хамтран ажиллах.

2. Энэ тогтоолыг хэрэгжүүлэхдээ Засгийн газар хоорондын хэлэлцээр, Ажлын хэсгүүд хоорондын албан ёсны хэлэлцээний протокол, аж ахуйн нэгж хоорондын хамтын ажиллагааны гэрээнүүд байгуулах, шаардлагатай бол эрх зүйн орчин бүрдүүлэх зорилгоор хууль тогтоомжийн төсөл санаачлах чиглэлээр ажиллахыг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т даалгасугай.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо /Г.Тэмүүлэн/-нд даалгасугай.

Гарын үсэг

**“МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ЗАСГИЙН
 ГАЗАР ХООРОНД ГАШУУНСУХАЙТ-ГАНЦМОД БООМТЫН ХИЛ ДАМНАСАН ТӨМӨР
 ЗАМЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭРИЙГ
 БАЙГУУЛАХАД БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ”
 УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ**

АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ

2024.12.25

Д/д	Нэр	Албан тушаал		Холбоо барих утас
Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам				
1.	Ц.Туваан	Сайд		
2.	С.Жавхланбаатар	Төрийн нарийн бичгийн дарга	-	
3.	Г.Намчинсүрэн	Эрдэс баялгийн бодлогын газрын дарга	-	99048753
4.	Т.Ганбаатар	Хуулийн хэлтсийн дарга	-	99991909
5.	Б.Хулан	Ашиглалт, ногоон хөгжлийн хэлтсийн дарга	-	88116333
Зам, тээврийн хөгжлийн яам				
6.	Б.Дэлгэрсайхан	Сайд		
7.	Б.Артур	Бодлого, төлөвлөлтийн газрын дарга	-	99117905
8.	Х.Итгэлт	Төмөр зам, далайн тээврийн бодлого, зохицуулалтын газрын дарга	-	99117418
Гадаад харилцааны яам				
9.	Б.Батмагнай	Хөрш орнуудын газрын дэд захирал	-	86000909
10.	Д.Бат-Өлзий	Гэрээ эрх зүйн газрын дэд захирал	-	99195050
“Эрдэнэс Тавантолгой” ХК				
11.	Х.Мөнхжаргал	Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч	-	99116597
12.	Ч.Алтанбагана	Уул уурхай, технологийн газрын дарга	-	99114533
13.	Э.Түвшинжаргал	Дотоод хяналт, эрсдлийн удирдлагын газрын дарга	-	88118191
14.	Э.Уянга	Хууль эрх зүйн газрын дарга	-	89003000
15.	О.Цэрэндондог	Борлуулалт, маркетинг, тээврийн газрын дарга	-	99147795